

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Жанчидын Ширэндэв	Дугаар	L212
Оршин суугаа аймаг	Увс аймаг	Оршин суугаа сум	Улаангом
Төрсөн газар	Улаангом	Төрсөн он	
Ажил мэргэжил	Улаангом хотын музейн тайлбарлагч		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дэжээлингийн хүрээ Төгс буянтын хүрээ, Улаангомьн хүрээ	Сүм хийдийн дугаар	УВХГ 013, УВТР 006
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 он 6-р сарын 7	Ярилцлага авсан хүн	С.Билэг-Өрнөх

Увс аймгийн Улаангом сумын Улаангомьн хүрээ, Хяргас сумын Дэжээлингийн хүрээ, Түргэн сумын Төгс буянтын хүрээ

Билэг-Өрнөх: Судалгааны багийн гишүүн Билэг-Өрнөх. За өнөөдөр 2007 оны 6 сарын 7-ны өдөр. Увс аймгийн төв Улаангом хотод байна. Орон нутгийн төв музейг судлах, Улаангом хотын музейн тайлбарлагч Жанчидын Ширэндэв гуайтай уулзаж байна аа.

Ширэндэв: За энэ Дэжээлингийн хүрээ гэж байгаа. Энэ баядын хошууны гол хүрээ нь , арван баядын хошууны гол хүрээ нь Дэжээлингийн хүрээ юм байгаа юм. За энд Дэжээлингийн хүрээ бол Дөрвөд далай хан аймгийн баядын дайчин вангийн хошуу буюу Баатар засгийн хошуу гэж байсан.Энэ хошуунд 1814 онд ван Салданжамц гэдэг тийм хүний санаачилгаар анх байгуулагдсан дацан юм байгаа юм. Тэгээд бол энд бол 9 дацан, 11 дуган, 10 жас 880 ламтай ийм хүрээ байсан гэж түүхэнд тэмдэглэгдсэн байх юм аа. За Намирын хүрээ буюу, Вангийн хүрээ гэж ингэж байсан юм байгаа юм. За энэ бол Дөрвөдийн Чин зоригт хааны Бишрэлт вангийн хошууны нутагт намжирт гэдэг газар анх 1881 онд байгуулагдсан. 4 дацан, 4 дугантай, 7 жас, 265 ламтай ийм хүрээ байсан байх юм. Ер нь Увс аймагт одоогийн бид нарын юугаар бол нэг 7, 8 орчим хүрээ байсан юм байна лээ.Зүгээр яахав бид нарт бол 4,5 хүрээ нь тодорхой тэмдэглэгдэж үлдсэн байх юм. За энэ Төгс буянтын хүрээ гэж. За энэ Төгс буянтын хүрээ бол Дөрвөдийн Зүүн гарын аймгийн Далай хааны хошуу одоогоор бол Увс аймгийн Түргэн сумын нутаг Дэлгэр мөрний баруун талд байгуулагдсан ийм хүрээ байгаа юм. За энэ бол 18-р зууны хоёрдугаар хагаст анх одоо Далай хаан санаачилж байгуулсан гэсэн ийм одоо мэдээлэл байдаг юм. За энэ хүрээ нь 10 дацан, 20 дуган, 13 жас 835 ламтай байжээ гэсэн ийм мэдээлэл бидэнд байгаа. Гэхдээ зүгээр энэ ламын тоо нь бол янз бүр байгаа юм. Тэр хэлмэгдэлтийн юугаар бол одоо тэр баримт материалыг харж байхад бол 1800 гаруй лам байсан гэж ингэж үзэж бас бичсэн байдаг юм. Аа мөн Түргэн сумын харъяат тухайн хийдэд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

шавилж байсан Гэнэн гэдэг хүний дуртатгал дээр бол бас 1800 гаруй лам байсан гэж ингэж одоо бичсэн байдаг юм байна лээ. За тэгээд энэ Төгс бүянтын хүрээнд одоо булгамал цаас хийж байсан ийм мэдээлэл бий. За энэ булгамал цаасан дээр бол Ноён Хутагт Данзанравжаа хүрч ирж одоо тэр Саран хөхөө туужаа тэр булгамал цаасан дээр бараар даруулж ингэж хэвлэж авч байсан гэсэн ийм баримт байгаа юм. Баримт гэж одоо ийм мэдээлэл байгаа юм. Энийг бол одоо тэр хүмүүс нь тэр булгамал цаасан дээр бүүлгасан юугаа өгөөч ээ, бидэнд үзүүлээч ээ гэхэд тэр хүмүүс нь үзүүлдэггүй нэг ийм юм байгаа юм аа. Улаангомын хүрээ гэж байгаа. За Улаангомын хүрээ нь бол Дөрвөд далай хан аймгийн Юндэнзоригт хааны хошуу буюу одоо яг энэ Улаангом хотын суурин дээр, одоо энэ Улаангом хотын байж байгаа газар байгуулагдсан. Баянчандмань гэдэг газар одоо 1754 онд байгуулагдсан гэсэн ийм мэдээлэл бий, за тэгээд 7 дацан, 9 дуган, 37 жас, 1603 ламтай байсан гэсэн ийм мэдээлэл бидэнд байж байгаа юм аа. За ер нь ингээд түүхийн зарим баримттай холбоод үзэхэд бол Улаангомын энэ анхны суурь нь бол 1686 оны үед үүссэн гэж үздэг юм байгаа юм. Яагаад гэхлээр Галдан бошигт хаан Хархираа голоос услалтын гараар суваг татаж усалгаатай анхны тариалангийн талбай бий болгосон. Тэгээд энэ анхны хийд байгуулсан үеийг хооронд нь харьцуулаад үзэхэд нэлээн тийм 50, 60-аад жилийн зөрүүтэй мэдээлэл байгаа юм. Зүгээр гэхдээ энэ 1754 он гэдэг нь бас ортой ч байж болох ийм л зүйл л дээ. За тэгээд ер нь цаашдаа болвол Увс аймагт Цалгарын хүрээ энэ тэр гээд олон хүрээнүүд байсан тийм нэг 7, 8 орчим хүрээ дацангууд байсан гэсэн тийм мэдээлэл бий. Энэ Цалгарын хүрээний талаар бол нэг их товч тодорхой мэдээлэл бидэнд алга байна аа. За ийм шив дээ.

Билэг- Өрнөх: За баярлалаа.